

# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын  
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт .....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт .....	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	9
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт .....	9
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт .....	9
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт .....	9
Статистик үзүүлэлтүүд .....	10
Харилцагчид, зээлдэгчид .....	10
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид .....	10
Тархалт .....	11
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	12
Мөнгөн хөрөнгө.....	13
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	14
Факторингийн тооцооны авлага.....	14
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө .....	15
Зээл.....	15
Цахим зээл.....	17
Ногоон зээл .....	18
Бусад хөрөнгө.....	19
Эргэлтийн бус хөрөнгө .....	20
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	20
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	21
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг .....	22
Бусад эх үүсвэр .....	22
ББСБ-аас гаргасан өрийн бичиг .....	23
Төслийн зээлийн санхүүжилт.....	24
Бусад өр төлбөр.....	24
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	25
Бусад өмч, сангууд .....	26
Хуримтлагдсан ашиг .....	26
Хоёрдогч өглөг.....	26
Ашигт ажиллагаа .....	27
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	29
Дүгнэлт .....	30
Актив, пассивын бүтэц.....	30
Ашигт ажиллагаа .....	30
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт .....	31

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл .....	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ .....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа .....	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	10
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	10
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл .....	11
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	11
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт .....	11
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт .....	11
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	12
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/ .....	13
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 15 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 16 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	15
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	16
Хүснэгт 19 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	17
Хүснэгт 20 Зээлийн ангилал .....	17
Хүснэгт 21 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд.....	18
Хүснэгт 22 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/ .....	19
Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	20
Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	20
Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/ .....	22
Хүснэгт 28 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/ .....	22
Хүснэгт 29 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 31 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/ .....	23
Хүснэгт 32 Өрийн бичиг /валютаар/ .....	24
Хүснэгт 34 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 35 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/ .....	24
Хүснэгт 36 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 37 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/ .....	25
Хүснэгт 38 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/ .....	26
Хүснэгт 39 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/ .....	26
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/ .....	27
Хүснэгт 42 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/ .....	28
Хүснэгт 43 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	29

### Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	12
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	13
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	14
Зураг 5 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/.....	15
Зураг 6 Зээлийн багцын чанар /хувиар/ .....	16
Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/ .....	17
Зураг 8 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/ .....	19
Зураг 9 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	21
Зураг 10 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	21
Зураг 11 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/ .....	22
Зураг 12 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/ .....	23
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	23
Зураг 14 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	25
Зураг 15 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	27

### Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2023 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 529 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 16 ББСБ буюу 3.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 24 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2019	2020	2021	2022	2023
Шинээр олгосон	14	14	14	17	32
Хүчингүй	15	20	12	38	16
Түдгэлзүүлсэн	13	34	29	65	33
Сэргээсэн	9	9	8	34	24
<b>Нийт ББСБ</b>	<b>538</b>	<b>532</b>	<b>534</b>	<b>513</b>	<b>529</b>
Үүнээс: ХОН	75	77	83	93	95
Үүнээс: ГХО	27	30	28	26	24
Салбар	250	295	331	427	446
Төлөөлөгч	7	9	8	8	11

2023 оны жилийн эцсийн байдлаар 32 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 16 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 33 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 24 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2023 оны жилийн эцсийн байдлаар 55 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2022	2023	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	3,527.0	4,672.2	32.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.7%	8.2%	0.5%
Нийт өөрийн хөрөнгө	2,191.6	2,745.3	25.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	49.2%	48.3%	-0.9%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,275.7	1,498.0	17.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	78.8%	90.2%	11.4%
Нийт зээл	2,722.6	3,675.9	35.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	12.1%	13.3%	1.2%
Нийт орлого	867.9	1,163.8	34.1%
Нийт зарлага	554.9	731.7	31.8%
Цэвэр ашиг	312.9	432.1	38.1%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 90.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 пунктээр өссөн дүн юм.

2023 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өсөж 4.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 51.6 хувийг өр төлбөрийн, 48.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 34.1 хувиар буюу 295.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 31.8 хувиар буюу 176.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 38.1 хувиар буюу 119.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022	2023	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	513	529	16	3.1%
1	Зээл	477	478	1	0.2%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	307	289	(18)	-5.9%
2	Факторингийн үйлчилгээ	45	54	9	20.0%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	27	(1)	-3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	6	1	20.0%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	37	46	9	24.3%
6	Гадаад валютын арилжаа	140	158	18	12.9%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	36	48	12	33.3%
7	Итгэлцлийн үйлчилгээ	64	82	18	28.1%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	22	34	12	54.5%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 529 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 90.4% нь буюу 478 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 54.6% нь буюу 289 ББСБ дагнан

эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 158 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 29.9 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 48 ББСБ нийт ББСБ-уудын 9.1 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцэл болон гадаад валютын арилжааны үйлчилгээг 18 ББСБ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 12 ББСБ, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 9 ББСБ тус тус нэмж авсан байна. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 дүгээр тогтоолоор нэр бүхий 39 ББСБ-ын

хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон ба 2023 оны жилийн эцсийн байдлаар 26 ББСБ тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон тухай өөрчлөлтөө улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлсэн байна.

2023 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 97.5% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 529 ББСБ-аас 516 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 13 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 8 ББСБ-аас 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

## Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- [“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”](#)-д Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамд 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/283 тоот албан бичгээр өөрчлөлтийг хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

- 2023 онд Цахим зөвлөлийн хуралдаанаар журмын шаардлага хангасан [43 ББСБ-ын 40 аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэсэн](#) байна. Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор цахим зээл олгож байгаа ББСБ-уудыг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлэх хугацаа өгсөн бол шинээр финтек зээлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ууд нь журмын шаардлагыг ханган, бүртгүүлэх хүсэлтээ ирүүлэх боломжтой. Журам батлагдсанаас хойш зөвшөөрөлгүй финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-уудад журамд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 498 дугаар тушаалаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, зааврыг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд СЗХ-ны 2023.03.13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, 82 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх,

тайлан мэдээ ирүүлэх журам”, 83 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох”, 84 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, 85 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6484-6488](#) тоот дугаарт бүртгүүлээ.

- Банкны тухай хуулийн 6.2-т заасны дагуу 2 банканд факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголоо. [2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор](#) Хаан банканд, [2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 97 дугаар тогтоолоор](#) Худалдаа хөгжлийн банканд тус тус олгосон байна.

- Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 1,200,000,000 /нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосон ба итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд 3 жил дараалан үе шаттай нэмэгдүүлэхээр тогтоосныг Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 6222 тоот дугаарт бүртгүүлсэн](#) байна.

- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах түүнд хяналт тавих журамд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 220 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдөр холбогдох хөдөлгөөн хийгдэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн байна.](#)

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 434 дүгээр тогтоолоор [Итгэлцлийн үйлчилгээний журмыг баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 6426 тоот дугаарт бүртгүүлсэн](#) байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 тоот тушаалаар “[Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам](#)”-ыг баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмын 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ нь ББСБ-ууд 2024 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайланг уг журмын дагуу гаргаж тайлагнана гэсэн үг юм.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 794 дүгээр тогтоолоор “[Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцаа тогтоох тухай](#)” тогтоолыг баталсан. Энэ нь итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд зээлийн багцын тодорхой хувийг ногоон таксономийн ангиллын ногоон зээлд гаргасан тохиолдолд өөрийн хөрөнгийн 100 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний итгэлцлийг бусдаас татан төвлөрүүлэхийг дэмжсэн бодлогын арга хэмжээ юм.



### Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2023 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 92.3 хувь буюу 468 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 86.9 хувь буюу 441 ББСБ хэрэгжүүлсэн байна.

### Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 478 ББСБ бүгд Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

### Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 130 ББСБ, 16,698 удаагийн тохиолдлоор, 3.4 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 158 удаагийн тохиолдлоор, 7.0 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 497 ББСБ-аас 1,225.7 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 99.7% буюу 489 ББСБ 1,222.8 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

## Статистик үзүүлэлтүүд

2023 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 30,419 хувьцаа эзэмшигчдийн 529 ББСБ, 446 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 5,009 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт давхардсан тоогоор 4.5 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

### Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар буурч давхардсан тоогоор 4,535,672-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар өсөж 1,600,427-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,535,672	3,833,466	265,383	4,270,289	85,172	4,497,105	38,567	424,783	102,669
Үүнээс: Эмэгтэй	2,466,520	2,083,004	133,865	2,332,655	42,242	2,445,169	21,351	231,063	54,839
Эрэгтэй	2,058,554	1,749,545	121,542	1,937,012	34,525	2,041,397	17,157	193,460	47,516
Хуулийн этгээд	10,591	910	9,976	615	8,405	10,532	59	260	314
Итгэмжлэгчдийн тоо	9,788	9,783	2,321	7,467	-	9,774	14	5,135	325
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,571	1,318	71	1,500	-	1,571	-	641	350
Зээлдэгчдийн тоо	1,600,427	998,363	174,671	1,425,756	-	1,563,648	36,779	201,564	102,669
Хэвийн	1,416,175	859,926	150,716	1,265,459	-	1,385,335	30,840	163,908	81,572
Хугацаа хэтэрсэн	58,972	46,770	6,637	52,335	-	57,279	1,693	15,361	9,089
Чанаргүй:	125,280	91,667	17,318	107,962	-	121,034	4,246	22,295	12,008
-Хэвийн бус	27,966	19,896	5,429	22,537	-	26,875	1,091	4,956	1,818
-Эргэлзээтэй	36,392	26,716	3,651	32,741	-	35,103	1,289	7,373	4,433
-Муу	60,922	45,055	8,238	52,684	-	59,056	1,866	9,966	5,757
Зээлдэгчдийн насжилт	1,598,614	997,527	173,397	1,425,217	-	1,561,891	36,723	201,292	102,355
18-35 насны	967,524	565,711	69,277	898,247	-	947,452	20,072	117,776	59,121
36-45 насны	400,381	270,123	56,688	343,693	-	390,805	9,576	53,569	26,750
46-55 насны	184,847	123,816	33,359	151,488	-	179,606	5,241	23,746	12,903
55-аас дээш	45,862	37,877	14,073	31,789	-	44,028	1,834	6,201	3,581
Зээлдэгчдийн боловсрол	1,598,614	997,527	173,397	1,425,217	-	1,561,891	36,723	201,292	102,355
-Дээд	872,827	620,574	95,132	777,695	-	852,944	19,883	120,341	67,520
-Тусгай дунд	148,724	79,492	13,428	135,296	-	144,648	4,076	19,694	14,041
-Бүрэн дунд	414,484	211,671	40,179	374,305	-	403,400	11,084	48,115	15,252
-Дунд	116,141	68,358	10,497	105,644	-	114,859	1,282	11,336	4,678
-Бага	46,438	17,432	14,161	32,277	-	46,040	398	1,806	864
Үүнээс: Иргэн	1,598,614	997,527	173,397	1,425,217	-	1,561,891	36,723	201,292	81,572
Хуулийн этгээд	1,747	771	1,224	523	-	1,691	56	272	9,089

/Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно.  
Зөвхөн финтек зээлийн мэдээллийг “Цахим зээл” хэсгээс үзнэ үү./

Нийт харилцагчдын 94.1% буюу 4,270,289 нь, зээлдэгчдийн 89.1% буюу 1,425,756 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 5.9% буюу 265,383 нь, зээлдэгчдийн 10.9% буюу 174,671 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 85,172 буюу нийт харилцагчдын 1.9 хувийг бүрдүүлж байна.

### Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,712	8,869	21,793	26,993	30,419	3,426	12.7%
Ажилчдын тоо	2,962	3,437	3,976	4,554	5,009	455	10.0%
Харилцагчдын тоо	2,854,530	2,844,782	4,820,624	4,633,616	4,535,672	(97,944)	-2.1%
Зээлдэгчдийн тоо	419,854	788,058	1,678,139	1,187,603	1,600,427	412,824	34.8%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.0%	2.8%	2.7%	3.1%	3.3%	+0.2пункт	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар буюу 3,426-гаар өсөж 30,419-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.6 хувь буюу 29,379 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,040 буюу 3.4% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа

эзэмшигчдийн 2,718 буюу 8.9% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 211 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	30,419	29,579	1,877	28,542	69	30,208	211	29,379	2,714
Нийт ажилтнуудын тоо	5,009	2,915	2,526	2,483	130	4,730	279	438	426
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,966	1,718	1,545	1,421	70	2,779	187	271	252
Эрэгтэй ажилтны тоо	2,043	1,197	981	1,062	60	1,951	92	167	174

Хөдөө орон нутгийн 95 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ТЗ-тэй ББСБ-ын тоо</b>	<b>529</b>	<b>82</b>	<b>474</b>	<b>55</b>	<b>48</b>	<b>434</b>	<b>95</b>	<b>5</b>	<b>524</b>	<b>25</b>
1 Зээл	478	82	423	55	-	387	91	5	473	24
2 Факторингийн үйлчилгээ	54	27	36	18	-	53	1	3	51	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	27	17	18	9	-	26	1	2	25	4
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	-	6	-	6	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	46	21	27	19	-	44	2	3	43	-
6 Гадаад валютын арилжаа	158	33	136	22	48	145	13	4	154	6
7 Итгэлцлийн үйлчилгээ	82	82	54	28	-	79	3	5	77	6
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	34	23	23	11	-	32	2	2	32	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

## Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.0% буюу 434 ББСБ, салбаруудын 61.4% буюу 274 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.0% буюу 95 ББСБ, салбаруудын 38.6% буюу 172 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 97 ББСБ-ын 446 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 56.7 хувийг 10 ББСБ-ын 253 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 434	Салбар 274	Нийт 708	Хувь 100.0%
Сүхбаатар дүүрэг	141	41	182	25.7%
Чингэлтэй дүүрэг	126	33	159	22.5%
Баянзүрх дүүрэг	46	67	113	16.0%
Баянгол дүүрэг	72	40	112	15.8%
Хан-Уул дүүрэг	39	33	72	10.2%
Сонгинохайрхан дүүрэг	9	50	59	8.3%
Багануур дүүрэг	1	6	7	1.0%
Налайх дүүрэг	-	4	4	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай, Дархан-Уул аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 93	Салбар 170	Нийт 263	Хувь 100%
Архангай аймаг	3	7	10	3.7%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.6%
Баянхонгор аймаг	4	8	12	4.5%
Булган аймаг	2	2	4	1.5%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	2	3	5	1.9%
Дархан-Уул аймаг	8	14	22	8.2%
Дорноговь аймаг	1	9	10	3.7%
Дорнод аймаг	5	14	19	7.1%
Дундговь аймаг	-	5	5	1.9%
Завхан аймаг	2	4	6	2.2%
Орхон аймаг	11	17	28	10.5%
Өвөрхангай аймаг	11	12	23	8.6%
Өмнөговь аймаг	2	14	16	6.0%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.5%
Сэлэнгэ аймаг	7	12	19	7.1%
Төв аймаг	18	6	24	9.0%
Увс аймаг	4	7	11	4.1%
Ховд аймаг	1	6	7	2.6%
Хөвсгөл аймаг	2	10	12	4.5%
Хэнтий аймаг	3	9	12	4.5%

## Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2023 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 4.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.5 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2022 дүн	Нийт дүнд эзлэх хувь	2023 дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	3,415,751.8	96.8%	4,526,175.8	96.9%	1,110,424.0	32.5%
Мөнгөн хөрөнгө	490,540.6	13.9%	652,934.2	14.0%	162,393.5	33.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	29,082.5	0.8%	50,718.4	1.1%	21,636.0	74.4%
Зээл (цэврээр)	2,571,251.2	72.9%	3,475,952.6	74.4%	904,701.4	35.2%
Нийт зээл	2,722,631.2	77.2%	3,675,862.2	78.7%	953,231.1	35.0%
<i>(Зээлийн эрсдэлийн сан)</i>	<i>151,379.9</i>	<i>4.3%</i>	<i>199,909.6</i>	<i>4.3%</i>	<i>48,529.7</i>	<i>32.1%</i>
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	9,719.2	0.3%	14,682.0	0.3%	4,962.8	51.1%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	24,161.4	0.7%	25,881.1	0.6%	1,719.7	7.1%
Бусад хөрөнгө	290,968.7	8.2%	302,055.5	6.5%	11,086.8	3.8%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	28.1	-	3,952.0	0.1%	3,923.9	-
Эргэлтийн бус хөрөнгө	111,207.5	3.2%	146,058.2	3.1%	34,850.7	31.3%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	146,101.7	4.1%	189,523.0	4.1%	43,421.3	29.7%
<i>(Хуримтлагдсан элэгдэл)</i>	<i>-34,894.2</i>	<i>-1.0%</i>	<i>-43,464.7</i>	<i>-0.9%</i>	<i>-8,570.6</i>	<i>24.6%</i>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,526,959.3</b>	<b>100.0%</b>	<b>4,672,234.0</b>	<b>100.0%</b>	<b>1,145,274.8</b>	<b>32.5%</b>


2023 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 8.2 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 13.3 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1,284.9 тэрбум төгрөг байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.6 дахин өсөж 4,257.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 96.9% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 363 ББСБ, 1.5% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 32 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.6 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 134 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	3,767.1	130	80.6%	24.6%	10.3	1	6.9	1	5.3	1
2.5-5.0 тэрбум	758.5	233	16.2%	44.0%	9.8	3	7.7	2	2.5	1
1.9-2.5 тэрбум	71.0	32	1.5%	6.0%	2.3	1	6.6	3	-	-
1.4-1.9 тэрбум	13.0	8	0.3%	1.5%	2.9	2	4.8	3	-	-
0.6-1.4 тэрбум	32.1	33	0.7%	6.2%	9.1	10	12.8	13	6.4	7
0.6 тэрбум хүртэлх	30.5	93	0.7%	17.6%	-	-	16.7	56	13.8	37
<b>НИЙТ</b>	<b>4,672.2</b>	<b>529</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>34.5</b>	<b>17</b>	<b>55.5</b>	<b>78</b>	<b>28.0</b>	<b>46</b>

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 2.5 их наяд төгрөг байгаа нь нийт активын 54.3 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 2.1 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 56.9 хувийг бүрдүүлж байна.

### Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 162.4 тэрбум төгрөгөөр буюу 33.1 хувиар өсөж 652.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 15.6% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 50.0% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 34.4% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	652.9	358.6	348.9	304.1	28.1	634.9	18.0	106.1	99.4
Бэлэн мөнгө	101.9	5.7	96.9	5.0	21.1	91.0	10.9	0.0	2.8
Харилцах	326.5	180.8	152.0	174.4	6.5	320.9	5.5	82.2	76.4
Хадгаламж	224.5	172.2	99.9	124.6	0.5	222.9	1.6	23.9	20.2

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 27.8%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.6%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 75.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



### Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтын цэвэр үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.7 дахин буюу 21.6 тэрбум төгрөгөөр өсөж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 32 ББСБ 50.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 41.3% буюу 20.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 58.7% буюу 29.8 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 50.5% буюу 25.6 тэрбум төгрөг нь хувьцаа, 44.9% буюу 22.8 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 3.4% буюу 1.7 тэрбум төгрөг нь засгийн газрын үнэт цаасаарх, 1.2% буюу 605.9 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	50,718.4	47,690.2	6,448.8	44,269.6	49,627.1	1,091.3	20,909.4	16,723.9
ЗГ-ын үнэт цаас	1,706.3	1,706.3	1.0	1,705.3	1,706.3	-	-	-
Хувьцаа	25,628.1	24,151.1	3,102.8	22,525.3	24,829.6	798.5	16,153.4	12,422.8
Өрийн бичиг	22,778.1	21,237.8	3,194.1	19,584.0	22,486.3	291.9	4,301.1	4,301.1
Бусад	605.9	594.9	151.0	454.9	604.9	1.0	454.9	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	29,764.7	29,023.7	3,970.5	25,794.2	29,023.1	741.6	7,628.1	3,801.1
Арилжааны үнэт цаас	20,953.7	18,666.5	2,478.3	18,475.4	20,604.0	349.7	13,281.3	12,922.8

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 34 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 32 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Эдгээрийн 75.0 хувь нь буюу тусгай зөвшөөрөлтэй 24 ББСБ-ын холбогдох дансанд 50.2 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт 1 ББСБ 1,705.3 сая төгрөгийн үнэт цаас бүртгэсэн байна.

Иймээс 8 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

### Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 51.1% буюу 5.0 тэрбум төгрөгөөр өсөж, 15 ББСБ 14.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2023 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 581.8 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 437.4 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 15.1 тэрбум төгрөгийн цэвэр факторингийн тооцооны авлагын үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2022		2023		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь
	9,860.0	100.0%	15,119.4	100.0%	5,259.4	53.3%
Хэвийн	9,337.9	94.7%	14,537.5	96.2%	5,199.6	55.7%
Анхаарал хандуулах	206.5	2.1%	263.8	1.7%	57.3	27.8%
Чанаргүй	315.6	3.2%	318.0	2.1%	2.4	0.8%
Хэвийн бус	132.3	1.3%	168.7	1.1%	36.4	27.5%
Эргэлзээтэй	171.9	1.7%	87.9	0.6%	(84.0)	-48.9%
Муу	11.4	0.1%	61.5	0.4%	50.0	438.0%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	140.8	1.4%	437.4	2.9%	296.6	210.7%



Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 54 ББСБ-уудын 39 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 2 банкны хувьд Хаан банк 2023 оны жилийн эцсийн байдлаар факторингийн авлагын үлдэгдэлгүй тухай тайлан ирүүлсэн бол Худалдаа хөгжлийн банк тайлан мэдээ ирүүлээгүй байна.

### Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.7 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар өсөж 25.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)</b>	25,881.1	15,875.3	20,167.3	5,713.8	25,881.0	0.1	1,051.0	24,830.1	2,687.5
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	29,473.1	19,067.8	21,076.0	8,397.1	29,473.1	-	2,836.2	26,636.9	2,195.1
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	7,411.5	4,404.9	4,143.3	3,268.2	7,411.5	-	1,800.3	5,611.2	1,528.1
Өмчлөх бусад хөрөнгө	3,819.5	1,212.4	3,234.6	584.9	3,819.4	0.1	15.1	3,804.4	2,020.4

### Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.0% буюу 953.2 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,675.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 199.9 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3,475.9 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	3,476.0	2,427.3	1,567.3	1,908.7	3,413.5	62.4	665.0	2,810.9	568.9
Нийт зээл	3,675.9	2,550.8	1,667.4	2,008.4	3,607.2	68.7	685.9	2,989.9	587.3
Хэвийн	3,297.4	2,317.0	1,469.1	1,828.3	3,238.4	58.9	639.3	2,658.1	544.4
Анхаарал хандуулах	119.4	79.3	61.5	58.0	117.5	2.0	19.2	100.3	16.9
Чанаргүй:	259.1	154.5	136.9	122.2	251.3	7.8	27.5	231.6	26.0
-Хэвийн бус	58.4	33.2	35.2	23.2	56.8	1.6	8.1	50.3	7.0
-Эргэлзээтэй	71.0	46.6	30.5	40.5	70.0	1.0	9.9	61.1	7.7
-Муу	129.7	74.7	71.2	58.5	124.5	5.2	9.5	120.2	11.3
(Зээлийн эрсдэлийн сан)	199.9	123.5	100.2	99.7	193.6	6.3	20.9	179.0	18.4
Нийт зээл (төгрөгийн)	3,581.7	2,466.4	1,650.5	1,931.2	3,513.0	68.7	652.9	2,928.8	553.5
Нийт зээл (валютын)	94.2	84.5	16.9	77.2	94.2	-	33.1	61.1	33.9
Зээлдэгчдийн тоо	1,600,427	998,363	174,671	1,425,756	1,563,648	36,779	201,564	1,398,863	102,669
- Иргэн	1,598,680	997,592	173,447	1,425,233	1,561,957	36,723	201,292	1,397,388	102,356
- Хуулийн этгээд	1,747	771	1,224	523	1,691	56	272	1,475	313

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 7.1 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 6.2 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,600,427 зээлдэгчийн 3.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/




Нийт зээлийн үлдэгдлийн 89.7 хувийг буюу 3.3 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.3 хувийг буюу 119.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.0 хувийг буюу 259.1 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 0.6 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 378.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 52.8%-д буюу 199.9 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 10.3% байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Олгосон зээлийн 90.6% буюу 6.5 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 9.4% буюу 674.2 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 90.9% буюу 5.6 их наяд төгрөг нь иргэдээс, 9.1% нь буюу 562.5 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	33,375.6	0.47%	25,935.2	0.4%	34,530.6	0.9%
2.	Уул уурхай, олборлолт	51,810.9	0.7%	44,562.6	0.7%	55,321.9	1.5%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	41,757.8	0.6%	40,354.9	0.7%	33,896.8	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	5,295.6	0.1%	5,000.9	0.1%	5,340.7	0.1%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,313.2	0.0%	2,426.7	0.0%	1,891.1	0.1%
6.	Барилга	245,895.3	3.4%	201,098.7	3.3%	247,088.2	6.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	524,653.2	7.3%	452,576.4	7.3%	381,209.0	10.4%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	139,018.0	1.9%	134,414.4	2.2%	100,186.8	2.7%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	134,295.1	1.9%	51,047.8	0.8%	127,063.4	3.5%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	98,361.7	1.4%	78,114.3	1.3%	113,869.6	3.1%
11.	Мэдээлэл холбоо	11,036.3	0.2%	8,423.1	0.1%	11,895.0	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	152,986.5	2.1%	136,189.1	2.2%	66,417.2	1.8%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	42,011.7	0.6%	31,457.6	0.5%	29,402.5	0.8%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4,918.9	0.1%	5,712.9	0.1%	4,165.5	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	21,272.6	0.3%	22,989.5	0.4%	19,236.4	0.5%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2,597.1	0.0%	7,058.9	0.1%	2,190.2	0.1%
17.	Боловсрол	19,127.7	0.3%	21,552.4	0.3%	16,159.6	0.4%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	13,801.1	0.2%	18,428.7	0.3%	14,162.1	0.4%
19.	Бусад	5,608,927.3	78.4%	4,891,640.6	79.2%	2,411,835.6	65.6%
Иргэнд олгосон зээл		6,479,260.7	90.6%	5,616,461.6	90.9%	3,243,838.2	88.2%
Хуулийн этгээдэд олгосон зээл		674,195.1	9.4%	562,523.0	9.1%	432,024.1	11.8%
<b>НИЙТ</b>		<b>7,153,455.8</b>	<b>100.0%</b>	<b>6,178,984.6</b>	<b>100.0%</b>	<b>3,675,862.2</b>	<b>100.0%</b>


Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл



ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 78.4% буюу 5.6 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 7.3% буюу 524.6 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 79.2% буюу 5.6 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 7.3% буюу 452.6 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон 3.7 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 26.1 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 24.0 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 3.7 их наядын зээлийн 55.1 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 22.9 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 10.0 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
<b>Иргэнд олгосон зээл</b>	<b>6,479.3</b>	<b>90.6%</b>	<b>5,616.5</b>	<b>90.9%</b>	<b>3,243.8</b>	<b>88.2%</b>
Хэрэглээнд зориулсан зээл	4,769.9	66.7%	4,205.0	68.1%	2,024.1	55.1%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	908.1	12.7%	644.6	10.4%	842.2	22.9%
Бизнес зориулсан зээл	973.6	13.6%	755.1	12.2%	788.8	21.5%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	175.0	2.4%	142.6	2.3%	183.1	5.0%
Бусад зээл	560.7	7.8%	513.7	8.3%	247.8	6.7%
<b>Хуулийн этгээдэд олгосон зээл</b>	<b>674.2</b>	<b>9.4%</b>	<b>562.5</b>	<b>9.1%</b>	<b>432.0</b>	<b>11.8%</b>
Бизнесийн зээл	563.7	7.9%	458.8	7.4%	365.9	10.0%
Автомашинны зээл	10.4	0.1%	6.6	0.1%	10.9	0.3%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	16.8	0.2%	17.0	0.3%	11.2	0.3%
Бусад зээл	83.3	1.2%	80.2	1.3%	44.0	1.2%
<b>НИЙТ</b>	<b>7,153.5</b>	<b>100.0%</b>	<b>6,179.0</b>	<b>100.0%</b>	<b>3,675.9</b>	<b>100.0%</b>

## Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2023 оны жилийн эцсийн байдлаар 55 ББСБ үзүүлж байна. 11 ББСБ тоо мэдээгээ ирүүлээгүй байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,917,350,357.3	79.4%	281,710	17.6%	10,355.9
Цахим зээл	758,511,884.2	20.6%	1,318,717	82.4%	575.2
<b>Нийт</b>	<b>3,675,862,241.5</b>	<b>100.0%</b>	<b>1,600,427</b>	<b>100.0%</b>	<b>2,296.8</b>

2023 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,318,717 зээлдэгчийн 758.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 82.4 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 20.6 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 575.2 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 18.0 дахин бага байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-д заасан шаардлагын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар 43 ББСБ аппликэйшнээр бүртгүүлснийг Санхүүгийн зохицуулах хорооны сайтад байршуулсан байна. Мөн бүртгэлтэй аппликэйшнээр зээл олгохоор 4 ББСБ мэдэгдсэн байна. Харин энэхүү журмын дагуу шаардлага ханган аппликэйшнээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхгүйгээр зээл олгож буй ББСБ-уудад хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 20 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
2	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03-№7/895
3	Ашид капитал	Simple, Simple Agent	2023.11.10-№7/4317
4	Инвескор	InvesCore, Pocket	2023.08.25-№7/3350, МЭДЭГДСЭН 2023.05.23 4077
5	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
6	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
7	Мобифинанс	Monpay	2023.06.20-№7/2540
8	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
9	Инвескор хэтэвч	Pocket	2023.05.08-№7/1871
10	Ардкредит	Ard app	2023.12.22-№7/4873
11	Тус финтек	Tus fintech	2023.05.19-№7/2125
12	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
13	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
14	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
15	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22-№7/4870
16	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
17	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
18	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
19	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08-№7/1872
20	Ньюстар финанс	Nsf.mn, Lite+	2023.06.20-№7/2552, 2023.06.20-№7/2553
21	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
22	Говьфинанс	CashOne	2023.08.25-№7/3354
23	Мөнгөнзоос кредит	Pocket	МЭДЭГДСЭН 2023.05.24 23/30
24	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
25	Финруут-Инвестмент	Pocket	МЭДЭГДСЭН 2023.05.24 23/43
26	Хас хаан	XACXAAH	2023.06.20-№7/2551
27	Гурван зуун жар файнанс	Minu pay	2023.07.04-№7/2822
28	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
29	Нанокапитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
30	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03-№7/889
31	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
32	Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
33	Инвеско фонд	IF.mn	2023.08.25-№7/3349
34	Номин юнити	Omni way	Зөвшөөрөлгүй
35	Кэйш флов финанс	tugrug app	Зөвшөөрөлгүй
36	Грийн финтек	t finance, green fintech	Зөвшөөрөлгүй
37	Централ капитал	knobi	Зөвшөөрөлгүй
38	Их монгол кредит	IkhMongolCredit	Зөвшөөрөлгүй
39	Төвхөн ингүүмэл	Oneclick	Зөвшөөрөлгүй
40	Жи Эс Би Капитал	GSB Prime, Mongolchat	Зөвшөөрөлгүй
41	Нэмэх төгрөг	Most Money	Зөвшөөрөлгүй
42	Начин заан финанс	Naizly	Зөвшөөрөлгүй
43	Өсөх ундарга финанс	ufinance	Зөвшөөрөлгүй
44	Смарткапитал фонд	My Credit	Зөвшөөрөлгүй
45	Фин экспресс	Finex	Зөвшөөрөлгүй
46	Онч-Энх	Ugloo	2023.03.30-№7/1297
47	Цогзолфинанс	Pocket	МЭДЭГДСЭН 2023.05.23 05/06
48	Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
49	Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
50	Голдман инвестмент групп	Goldpay	2023.08.25-№7/3355
51	Соломон инвестментс	M Credit	2023.11.10-№7/4319
52	Сэндмн	Pocket	МЭДЭГДСЭН 2023.12.20 23/235
53	Изи пэй норбула	Easy pay.mn	2023.12.22-№7/4867
54	Микрокредит	Easy	2023.12.22-№7/4871
55	Эс Ай Си Эй финанс	Khanguud	2023.12.22-№7/4872

НИЙТ

/"Инвескор хэтэвч ББСБ" ХХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 5 ББСБ байна. Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 6 ББСБ-ыг саарлаар тэмдэглэв/

**Ногоон зээл**

Тайлант хугацаанд 28 ББСБ 7,922 зээлдэгчид 142.0 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.9 хувийн хүүтэйгээр олгож, 29 ББСБ-ын 18,449 зээлдэгчээс 102.6 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 34 ББСБ 11,383 зээлдэгчийн 155.9 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 4.2%-тай тэнцэж байна. Үүнээс 5-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээврийн

хэрэгслийн дүнг хасаж тооцвол ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн “0.3” хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 21 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	301.5	31.0	99.8	31.0	201.6	23.0
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	4,982.3	186.0	3,893.8	145.0	1,088.5	42.0
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	143.0	61.0	431.7	44.0	2,241.3	98.0
4. НОГООН БАРИЛГА	2,149.2	173.0	2,002.6	189.0	7,071.9	743.0
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	49.9	1.0	-	-
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	713.3	6.0	707.7	18.0	799.6	14.0
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	133,750.9	7,465.0	95,391.3	18,021.0	144,482.2	10,463.0
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	585.3	23.0	354.3	22.0	770.0	41.0
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	92,459.5	4,265.0	75,521.8	13,953.0	92,512.6	6,137.0
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	40,706.1	3,177.0	19,515.1	4,046.0	51,199.5	4,285.0
<b>НИЙТ</b>	<b>142,040.1</b>	<b>7,922.0</b>	<b>102,576.8</b>	<b>18,449.0</b>	<b>155,885.0</b>	<b>11,383.0</b>

Ногоон зээлийн үлдэгдлийн 92.7% буюу 144.5 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа, тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 95.5% нь хэвийн, 2.8% нь анхаарал хандуулах, 1.7% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилга болон Карбон бага ялгаруулдаг тээврийн салбарын зээлийн үлдэгдэл харгалзан 3.1%, 1.7% буюу хамгийн их хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



### Бусад хөрөнгө

2023 оны жилийн эцсийн байдлаарх 302.1 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 53.5% буюу 161.7 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 24.3% буюу 73.4 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 22.2% буюу 66.9 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>	<b>302,055.5</b>	<b>169,858.6</b>	<b>167,139.4</b>	<b>134,916.1</b>	<b>254.8</b>	<b>296,630.7</b>	<b>5,424.9</b>	<b>35,538.7</b>	<b>31,681.2</b>
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	161,691.0	90,177.2	94,406.1	67,285.0	-	159,385.7	2,305.4	18,589.0	18,912.5
-Үнэт цаасны	744.5	391.0	396.7	347.8	-	744.5	-	229.9	353.5
-Зээлийн	154,868.1	84,414.6	92,616.5	62,251.6	-	152,563.0	2,305.1	17,791.4	18,431.5
-Факторингийн	297.2	219.2	73.3	223.9	-	297.2	-	-	-
-Бусад	5,781.2	5,152.4	1,319.6	4,461.7	-	5,781.0	0.2	567.8	127.5
Авлага /цэврээр/	73,424.1	37,181.2	42,064.1	31,360.0	246.7	71,716.3	1,707.8	11,082.7	8,778.7
Нийт авлага	75,921.6	39,409.2	42,698.2	33,223.5	246.7	74,208.2	1,713.4	11,251.8	9,136.5
Хэвийн	72,662.6	36,601.2	41,725.2	30,937.4	243.2	70,962.6	1,699.9	10,812.6	8,505.9
Хугацаа хэтэрсэн	390.3	375.2	172.4	217.9	3.5	382.0	8.3	182.6	184.6
Чанаргүй:	2,868.8	2,432.7	800.6	2,068.2	-	2,863.6	5.2	256.5	446.1
-Хэвийн бус	167.5	167.1	0.5	167.0	-	167.5	-	122.5	121.3
-Эргэлзээтэй	194.9	191.2	3.7	191.1	-	194.9	-	9.4	13.1
-Муу	2,506.4	2,074.4	796.4	1,710.0	-	2,501.3	5.2	124.6	311.7
Нийт авлага (валютын)	75,303.4	38,794.3	42,435.4	32,867.9	246.7	73,590.0	1,713.4	11,251.8	9,136.5
Нийт авлага (төгрөгийн)	618.3	614.8	262.8	355.5	-	618.3	-	0.0	-
(Авлагын эрсдэлийн сан)	2,497.5	2,228.0	634.1	1,863.5	-	2,492.0	5.6	169.0	357.8
Бусад актив	66,940.4	42,500.2	30,669.3	36,271.1	8.1	65,528.7	1,411.7	5,867.0	3,989.9

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2023 оны жилийн эцсийн байдлаар 189.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 43.5 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 146.1 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

<b>ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>	<b>Нийт</b>	<b>Итгэлцэл</b>	<b>Уламжлалт</b>	<b>Финтек</b>	<b>ЗГВА</b>	<b>УБ</b>	<b>ХОН</b>	<b>ХК</b>	<b>ГХО</b>
<b>Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө</b>	<b>146.1</b>	<b>88.3</b>	<b>64.2</b>	<b>81.9</b>	<b>0.2</b>	<b>143.1</b>	<b>3.0</b>	<b>18.6</b>	<b>16.4</b>
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	189.5	111.8	84.3	105.2	0.33	185.4	4.1	23.2	21.5
Барилга байгууламж	62.1	43.0	21.1	41.0	0.09	60.6	1.5	6.4	6.1
Техник хэрэгсэл	65.6	28.3	39.7	25.9	0.05	63.7	1.9	4.2	5.5
Тавилга эд хогшил	22.2	13.2	11.6	10.7	0.19	21.8	0.5	4.1	4.8
Дуусаагүй барилга	9.6	4.1	7.8	1.8	-	9.6	0.0	0.01	-
Биет бус хөрөнгө	30.0	23.2	4.2	25.7	0.001	29.7	0.3	8.5	5.1
(Хуримтлагдсан элэгдэл)	43.5	23.5	20.2	23.3	0.14	42.4	1.1	4.6	5.1
Барилга байгууламжийн	9.0	6.9	2.6	6.5	0.004	8.9	0.2	0.8	0.1
Техник хэрэгслийн	25.8	11.3	13.2	12.6	0.03	25.0	0.8	2.1	2.8
Тавилга эд хогшлын	8.6	5.4	4.4	4.2	0.10	8.4	0.2	1.7	2.1

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 51.6 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2022	Нийт дүнд	2023	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Өр төлбөр	1,335,379.9	37.9%	1,926,887.2	41.2%	591,507.3	44.3%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	381,147.1	10.8%	651,891.5	14.0%	270,744.4	71.0%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	396,763.2	11.2%	586,361.6	12.5%	189,598.4	47.8%
Бусад эх үүсвэр	48,136.3	1.4%	46,984.0	1.0%	(1,152.3)	-2.4%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	228,300.0	6.5%	316,309.6	6.8%	88,009.6	38.5%
Төслийн зээлийн санхүүжилт	29,990.8	0.9%	23,777.2	0.5%	(6,213.7)	-20.7%
Бусад өр төлбөр	251,042.5	7.1%	301,563.4	6.5%	50,520.9	20.1%
Эздийн өмч	2,191,579.4	62.1%	2,745,346.8	58.8%	553,767.5	25.3%
Хувьцаат капитал	1,275,684.5	36.2%	1,497,971.1	32.1%	222,286.6	17.4%
Бусад өмч	62,333.2	1.8%	62,570.0	1.3%	236.8	0.4%
Сангууд	2,724.2	0.1%	1,583.8	0.03%	(1,140.4)	-41.9%
<b>Хуримтлагдсан ашиг/алдагдал</b>	<b>774,842.4</b>	<b>22.0%</b>	<b>1,107,226.8</b>	<b>23.7%</b>	<b>332,384.5</b>	<b>42.9%</b>
Хоёрдогч өглөг	75,995.0	2.2%	75,995.0	1.6%	-	0.0%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>3,526,959.3</b>	<b>100.0%</b>	<b>4,672,234.0</b>	<b>100.0%</b>	<b>1,145,274.8</b>	<b>32.5%</b>

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 71.0 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 47.8 хувиар ББСБ-аас гаргасан өрийн бичиг 38.5 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 42.9 хувиар өсөж, сангууд 41.9 хувиар буурсан байна.


Сүүлийн 5 жилийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2018 оны мөн үед өөрийн хөрөнгө банкны салбарын 30.0 хувьд хүрдэг байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 48.3 хувьд хүрч байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 90.2 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 35.1 хувьтай тэнцдэг байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 1.2 пунктээр өсөж 36.3 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2023 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өсөж 2.7 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 6.3 дахин өсөж 1.9 их наяд төгрөгт хүрсэн байна.

Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/




### Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2023 оны жилийн эцсийн байдлаар өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг итгэлцлийн үйлчилгээний өглөг үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 71.0% буюу 270.7 тэрбум

төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 78 ББСБ 9,796 итгэмжлэгчээс 651.9 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 75 ББСБ 9,770 итгэмжлэгчээс 650.0 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 3 ББСБ 14 итгэмжлэгчээс 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Итгэлцлийн үйлчилгээний өглөг</b>	<b>651.9</b>	<b>158.4</b>	<b>493.5</b>	<b>650.0</b>	<b>1.9</b>	<b>217.5</b>	<b>434.4</b>	<b>150.3</b>
-Төгрөгөөр	587.8	149.0	438.8	585.9	1.9	189.2	398.6	150.3
-Валютаар	64.1	9.4	54.7	64.1	-	28.3	35.8	146.7
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	82	54	28	79	3	5	77	6
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	78	50	28	75	3	5	73	6
Нийт итгэмжлэгчдийн тоо	9,796	2,316	7,480	9,782	14	5,135	4,661	325

Нэр бүхий нэг ББСБ хамгийн өндөр дүнгээр буюу 133.2 тэрбум төгрөгийг 235 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол нэр бүхий нэг ББСБ хамгийн олон буюу 4,094 итгэмжлэгчээс дунджаар 5.9 сая төгрөг нийт 24.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2023 оны жилийн эцсийн байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 47.8 хувиар өсөж, 109 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 586.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 26 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг</b>	<b>586.4</b>		<b>477.6</b>	<b>208.0</b>	<b>378.3</b>	<b>584.1</b>	<b>2.3</b>	<b>232.9</b>	<b>353.5</b>	<b>205.2</b>
Хугацаагаар:										
Богино хугацааг зээл	255.5	43.6%	211.9	112.6	142.9	254.8	0.7	92.7	162.9	82.9
Урт хугацааг зээл	330.8	56.4%	265.7	95.4	235.4	329.3	1.5	140.2	190.6	122.3
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	433.2	73.9%	341.8	146.3	286.9	430.9	2.3	160.6	272.6	124.9
Валютаар	153.2	26.1%	135.8	61.7	91.5	153.2	-	72.3	80.9	80.3
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	449.1	76.6%	356.7	147.2	301.8	446.8	2.3	174.0	275.0	130.0
Зээл /төгрөгөөр/	433.2	73.9%	341.8	146.3	286.9	430.9	2.3	160.6	272.6	124.9
Зээл /валютаар/	15.9	2.7%	14.9	0.9	15.0	15.9	-	13.5	2.4	5.1
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	137.3	23.4%	120.8	60.8	76.5	137.3	-	58.8	78.5	75.2

### Бусад эх үүсвэр

2023 оны жилийн эцсийн байдлаар 16 ББСБ 47.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ.



Хүснэгт 27 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
<b>Нийт</b>	<b>46,984.0</b>	<b>100.0%</b>	<b>36,800.3</b>	<b>8,857.2</b>	<b>38,126.7</b>	<b>46,984.0</b>	<b>227.6</b>
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	5,663.3	12.1%	5,582.5	80.8	5,582.5	5,663.3	227.6
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	9,260.7	19.7%	9,113.7	147.0	9,113.7	9,260.7	-
Факторингийн үйлчилгээний өглөг	32,060.0	68.2%	22,104.1	8,629.4	23,430.5	32,060.0	-

Үүнээс нэр бүхий 4 ББСБ 5.7 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 2 ББСБ 9.3 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 10 ББСБ 32.1 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ.

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулга болон факторингийн үйлчилгээний өглөг харгалзан 53.6%, 10.4 хувиар тус тус буурсан бол факторингийн үйлчилгээний өглөг 64.9 дахин өссөн байна. Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг, гадаад валют арилжааны эх үүсвэр тус тус 4.6, 14.9 дахин өссөн байна.

Зураг 11 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2019	2020	2021	2022	2023
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	-	-	-	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	3,991,020.4	5,985,400.3	14,809,952.7	12,217,667.8	5,663,328.2
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	4,400,897.2	5,652,901.9	316,837.0	142,735.6	9,260,655.8
Факторингийн үйлчилгээний өглөг	24,873,518.3	31,512,175.2	39,234,782.4	35,775,861.1	32,059,983.3
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	112.5	-	-
<b>Нийт</b>	<b>33,265,435.8</b>	<b>43,150,477.5</b>	<b>54,361,684.6</b>	<b>48,136,264.5</b>	<b>46,983,967.3</b>

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

### ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2023 оны жилийн эцсийн байдлаар 34 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,629 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 316.3 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 28 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/


ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
		<b>316,309.6</b>	<b>290,557.1</b>	<b>44,850.1</b>	<b>271,459.5</b>	<b>316,309.6</b>	-	<b>85,595.6</b>	<b>230,714.0</b>
Төгрөгөөр	303,762.9	278,218.7	44,641.8	259,121.1	303,762.9	-	85,595.6	218,167.4	65,255.4
Валютаар	12,546.7	12,338.4	208.3	12,338.4	12,546.7	-	-	12,546.7	-

Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 13.5 дахин өсөж 316.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 12 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 5.0 хувь байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 1.0 пунктээр буурч 4.0 хувьд хүрсэн байна.



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 263 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг хүчингүй болгосонтой холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

### Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 7 ББСБ 23.8 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	23,777.2		13,250.2	16,816.1	6,961.1	23,777.2	-	3,061.1	20,716.0	9,150.1
<b>Хугацаагаар</b>										
Богино хугацаат	8,998.1	37.8%	6,100.1	2,037.0	6,961.1	8,998.1	-	3,061.1	5,936.9	2,000.0
Урт хугацаат	14,779.1	62.2%	7,150.1	14,779.1	-	14,779.1	-	-	14,779.1	7,150.1
<b>Төрлөөр</b>										
Засгийн газрын	1,002.0	0.04	1,002.0	-	1,002.0	1,002.0	-	-	1,002.0	-
Гадаадын	10,211.2	42.9%	10,211.2	7,150.1	3,061.1	10,211.2	-	3,061.1	7,150.1	7,150.1
Дотоодын	2,227.3	9.4%	2,037.0	2,227.3	-	2,227.3	-	-	2,227.3	2,000.0
Бусад	10,336.7	43.5%	-	7,438.8	2,897.9	10,336.7	-	-	10,336.7	-
<b>Валютын төрлөөр</b>										
Төгрөгөөр	20,757.3	87.3%	10,230.3	13,796.2	6,961.1	20,757.3	-	3,061.1	17,696.1	6,130.2
Валютаар	3,019.9	12.7%	3,019.9	3,019.9	-	3,019.9	-	-	3,019.9	3,019.9

### Бусад өр төлбөр

2023 оны жилийн эцсийн байдлаар 496 ББСБ 301.6 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 19.6% буюу 59.0 тэрбум төгрөг нь 87 ББСБ-ын хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 80.4% буюу 242.3 тэрбум төгрөг нь 496 ББСБ-ын бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	301,563.4	221,921.3	81,905.0	219,658.4	289.9	297,778.6	3,784.8	61,560.7	240,002.7	42,343.0
<b>Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>	59,004.1	47,732.4	10,602.2	48,402.0	136.6	58,938.5	65.7	17,387.0	41,617.2	13,395.3
<b>Ангиллаар</b>										
Эзлийн	21,642.2	10,995.8	5,248.8	16,393.4	136.6	21,640.7	1.5	4,213.1	17,429.1	3,342.8
Үнэт цаасны	5,633.5	5,054.4	160.7	5,472.8	-	5,633.5	-	2,052.2	3,581.3	1,574.1
Бусад	31,728.4	31,682.2	5,192.7	26,535.7	-	31,664.2	64.2	11,121.7	20,606.8	8,478.4
<b>Валютын төрлөөр</b>										
Төгрөгөөр	54,041.4	43,023.3	9,700.9	44,340.5	136.6	53,975.7	65.7	15,458.1	38,583.2	11,788.9
Валютаар	4,962.8	4,709.1	901.3	4,061.5	-	4,962.8	-	1,928.8	3,033.9	1,606.4
<b>Бусад пассив</b>	242,310.9	173,940.6	71,302.8	171,008.1	153.3	238,591.8	3,719.1	43,925.3	198,385.5	28,699.3



## Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/


Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	1,497,971.1	543,054.7	1,079,126.5	418,844.6	21,059.5	1,440,567.9	57,403.3	40,300.0	1,457,671.1	110,476.0
Энгийн хувьцаа	1,498,319.8	543,566.7	1,079,137.6	419,182.2	21,059.5	1,440,958.8	57,361.0	42,641.1	1,455,678.7	110,358.6
Давуу эрхтэй хувьцаа	2,199.3	2,036.0	199.3	2,000.0	-	2,157.0	42.3	-	2,199.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.5	-	2,548.0	-	2,341.1	206.8	3.6

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.4% буюу 222.3 тэрбум төгрөгөөр өсөж 1.5 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 32.1 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаат капиталын хэмжээ 2018 оны мөн үеэс 2.0 дахин өсөж 1.5 их наяд төгрөгт, үүнээс энгийн хувьцаа 2.0 дахин өсөж 1.5 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 3.4 дахин өсөж 2.3 тэрбум төгрөгт, халаасны хувьцаа 12.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 529 ББСБ-ын 1.5 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.3 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 393 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.3% буюу 1.4 их наяд төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 136 ББСБ-ын 55.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.7 хувийг, ББСБ-уудын 25.7 хувийг бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 286.4 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 19.1 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 1.5 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 78.9 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. Иймд эдгээр ББСБ-уудын хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	488.6	38	32.6%	7.2%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	909.3	332	60.7%	62.8%	5.8	2	7.0	2	3.0	1
1.9-2.5 тэрбум	44.5	23	3.0%	4.3%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	8.4	6	0.6%	1.1%	2.8	2	2.8	2	1.4	1
0.6-1.4 тэрбум	18.4	23	1.2%	4.3%	8.5	12	6.0	7	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	28.7	107	1.9%	20.2%	-	-	15.3	66	13.4	41
<b>НИЙТ</b>	<b>1,498.0</b>	<b>529</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>24.3</b>	<b>17</b>	<b>33.1</b>	<b>78</b>	<b>20.7</b>	<b>46</b>

## Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсөж 62.6 тэрбум төгрөгт, сангууд 41.9 хувиар буурч 1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Бусад өмч</b>	<b>62,570.0</b>	<b>57,473.6</b>	<b>12,283.7</b>	<b>50,286.3</b>	<b>145.5</b>	<b>62,150.3</b>	<b>419.8</b>	<b>51,886.3</b>	<b>10,683.7</b>	<b>39,285.7</b>
НТК	58,425.2	57,189.7	10,709.4	47,715.9	110.4	58,178.0	247.3	52,994.3	5,430.9	39,283.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,108.1	(457.5)	1,308.3	1,799.8	-	3,067.0	41.1	(1,165.3)	4,273.4	1.8
Хандивын капитал	1,036.7	741.3	266.1	770.6	35.0	905.3	131.4	57.3	979.3	-
<b>Сангууд</b>	<b>1,583.8</b>	<b>590.6</b>	<b>2,142.6</b>	<b>(558.7)</b>	<b>-</b>	<b>783.7</b>	<b>800.1</b>	<b>(575.8)</b>	<b>2,159.6</b>	<b>(574.7)</b>
Нөөцийн сан	1,109.7	554.9	1,700.5	(590.8)	-	561.4	548.3	(590.9)	1,700.6	(576.0)
Нийгмийн хөгжлийн сан	474.1	35.7	442.1	32.0	-	222.3	251.8	15.1	459.0	1.2

## Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 42.9% буюу 332.4 тэрбум төгрөгөөр өсөж 1,107.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 459 ББСБ нийт 440.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 10 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 60 ББСБ 8.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




## Хоёрдогч өглөг

Хоёрдогч өглөгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс өөрчлөлт ороогүй бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 8 ББСБ 76.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

## Ашигт ажиллагаа

2023 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 1,163.8 тэрбум төгрөгийн орлого олж, 731.7 тэрбум төгрөгийн зардал гаргаж 432.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 34.1% буюу 295.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 31.8% буюу 176.7 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 38.1% буюу 119.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2022	2023	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	701,959,166.1	999,060,655.0	85.8%	297,101,489.0	42.3%
Хүүгийн бус орлого	149,892,765.1	140,007,138.8	12.0%	-9,885,626.3	-6.6%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	82,950,313.7	98,929,938.2	8.5%	15,979,624.5	19.3%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	64,518.0	48,006.5	0.0%	-16,511.6	-25.6%
- Мөнгөн гуйвуулгын орлого	2,747,549.5	4,805,570.7	0.4%	2,058,021.3	74.9%
- Картын үйлчилгээний орлого	-	1,347.5	0.0%	1,347.5	#DIV/0!
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	477,220.9	-	0.0%	-477,220.9	-100.0%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	67,576,176.8	67,326,243.0	5.8%	-249,933.8	-0.4%
- Бусад	12,084,520.7	26,748,770.5	2.3%	14,664,249.7	121.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,821,216.4	24,502,906.0	2.1%	8,681,689.5	54.9%
Ердийн бус орлого	183,109.3	226,779.7	0.02%	43,670.5	23.8%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>867,856,256.8</b>	<b>1,163,797,479.6</b>	<b>100.0%</b>	<b>295,941,222.7</b>	<b>34.1%</b>
<b>ЗАРДАЛ</b>					
Хүүгийн зардал	95,642,360.0	139,996,435.5	19.1%	44,354,075.5	46.4%
Хүүгийн бус зардал	335,215,597.3	412,365,486.4	56.4%	77,149,889.2	23.0%
Болзошгүй эрсдэлийн зардал	69,068,740.7	93,453,042.7	12.8%	24,384,302.0	35.3%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	8,216,476.5	12,704,602.1	1.7%	4,488,125.6	54.6%
Орлогын албан татварын зардал	46,764,319.4	72,945,387.3	10.0%	26,181,067.9	56.0%
Ердийн бус зардал	34,262.9	206,480.8	-	172,217.9	502.6%
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>554,941,756.8</b>	<b>731,671,434.9</b>	<b>100.0%</b>	<b>176,729,678.1</b>	<b>31.8%</b>
<b>АШИГ</b>					
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>312,914,500.1</b>	<b>432,126,044.7</b>	<b>100.0%</b>	<b>119,211,544.6</b>	<b>38.1%</b>

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд үндсэн бус үйл ажиллагааны орлого 54.9 хувиар өсжээ. Түүн дотроо ногдол ашгийн орлого 30.8 дахин, тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөгдөлт 3.0 дахин өссөн байна.

Хүүгийн орлогын хувьд Засгийн газрын үнэт цаасны орлого 9.6 дахин, гадаадын оршин суугчдын хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого 6.7 дахин, өрийн бичгийн хүүгийн орлого 4.7 дахин, банкин дахь харилцах дансны хүүгийн орлого 4.0 дахин өссөн байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь ердийн бус зардал байна. Ердийн бус зардал 6.0 дахин өсөж 206.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

<b>ОРЛОГО</b>	<b>Нийт</b>	<b>Итгэлцэл</b>	<b>Уламжлалт</b>	<b>Финтек</b>	<b>ЗГВА</b>	<b>УБ</b>	<b>ХОН</b>	<b>ХК</b>	<b>ГХО</b>
Хүүгийн орлого	999,060.7	718,249.7	408,787.4	590,273.2	52.9	980,893.5	18,167.2	179,551.2	143,195.8
Хүүгийн бус орлого	140,007.1	99,152.9	36,901.3	103,105.9	3,619.6	137,012.5	2,994.7	25,456.7	6,455.4
- Санхүүгийн үйлчилгээний орлого	98,929.9	69,672.4	20,145.7	78,784.2	0.1	96,009.4	2,920.6	22,305.2	4,631.6
<i>Итгэлцлийн үйлчилгээний орлого</i>	48.0	48.0	20.5	27.5	-	48.0	-	1.8	-
<i>Мөнгөн гуйвуулгын орлого</i>	4,805.6	4,190.9	598.1	4,207.4	-	4,805.0	0.6	595.7	-
<i>Картын үйлчилгээний орлого</i>	1.3	1.3	-	1.3	-	1.3	-	1.3	-
<i>Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого</i>	-	-	-	-	-	-	-	-	-
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	67,326.2	58,279.8	10,640.1	56,686.1	-	64,558.7	2,767.6	20,922.1	4,022.6
<i>Бусад</i>	26,748.8	7,152.3	8,887.0	17,861.8	0.1	26,596.3	152.4	784.3	609.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	24,502.9	17,244.0	11,632.9	12,870.0	-	23,472.9	1,030.0	7,053.9	5,745.6
Ердийн бус орлого	226.8	53.2	195.3	31.4	0.0	193.7	33.1	-	-
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,163,797.5</b>	<b>834,699.9</b>	<b>457,516.9</b>	<b>706,280.6</b>	<b>3,672.5</b>	<b>1,141,572.5</b>	<b>22,224.9</b>	<b>212,061.8</b>	<b>155,396.8</b>
<b>ЗАРДАЛ</b>									
Хүүгийн зардал	139,996.4	123,130.8	43,905.0	96,091.4	-	139,359.7	636.7	32,315.4	24,146.4
Хүүгийн бус зардал	412,365.5	299,949.7	135,793.5	276,572.0	1,767.8	404,855.3	7,510.2	79,534.6	59,423.7
Болзошгүй эрсдэлийн зардал	93,453.0	60,595.0	36,444.9	57,008.1	-	91,468.0	1,985.0	16,551.3	10,285.7
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	12,704.6	6,989.2	6,460.4	6,244.2	5.0	12,458.4	246.2	1,317.0	2,112.1
Орлогын албан татварын зардал	72,945.4	57,171.7	26,541.5	46,403.9	73.5	72,299.6	645.8	17,379.4	12,396.5
Ердийн бус зардал	206.5	172.3	193.9	12.5	-	206.4	0.0	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>731,671.4</b>	<b>548,008.7</b>	<b>249,339.3</b>	<b>482,332.1</b>	<b>1,846.3</b>	<b>720,647.4</b>	<b>11,024.0</b>	<b>147,097.6</b>	<b>108,364.5</b>
<b>АШИГ</b>									
<b>ЦЭВЭР ОРЛОГО</b>	<b>432,126.0</b>	<b>286,691.1</b>	<b>208,177.6</b>	<b>223,948.4</b>	<b>1,826.2</b>	<b>420,925.1</b>	<b>11,200.9</b>	<b>64,964.2</b>	<b>47,032.2</b>

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 529 ББСБ-ын 87.7% буюу 464 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 12.3% нь буюу 65 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 57 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 5 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 5 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 38 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцлэл /82 ББСБ/		Итгэлцлэл, ГВА-аас бусад /399 ББСБ/		ЗГВА /48 ББСБ/		Нийт /529 ББСБ/			
		√	X	√	X	√	X	√	X		
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	398	1	48	-	528	1		
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	396	3	48	-	526	3		
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	82	-	397	2	48	-	527	2		
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	80	2	388	11	48	-	516	13		
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу )	78	4	381	18	47	1	506	23		
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	392	7	XXX		522	7		
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	81	1	398	1			527	2		
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	398	1			528	1		
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “Г” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	82	-	399	-			529	-		
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	391	8			521	8		
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80	2	XXX				520	527		
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	82	-	397	2			527	2		
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	80	2	387	12			48	-	515	14

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо  
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 23 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

## Дүгнэлт

2023 оны жилийн эцсийн байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 529 ББСБ-аас 516 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 13 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 30,419 хувьцаа эзэмшигчдийн 529 ББСБ, 446 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 5,009 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт давхардсан тоогоор 4.5 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

### Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 90.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 пунктээр өссөн дүн юм.

2023 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өсөж 4.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 51.6 хувийг өр төлбөрийн, 48.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /150 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.0% буюу 953.2 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,675.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 199.9 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3,475.9 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Тайлант улиралд ББСБ-ууд 7.1 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 6.2 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,600,427 зээлдэгчийн 3.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 89.7 хувийг буюу 3.3 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.3 хувийг буюу 119.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.0 хувийг буюу 259.1 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 1.2 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 0.6 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 378.5 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 52.8%-д буюу 199.9 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 10.3% байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар буюу 1.1 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 51.6 хувийг өр төлбөрийн өсөлт, 48.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 71.0 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 47.8 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 38.5 хувиар тус тус өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна.

### Ашигт ажиллагаа

2023 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 1,163.8 тэрбум төгрөгийн орлого олж, 731.7 тэрбум төгрөгийн зардал гаргаж 432.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх

оны мөн үеэс орлогын хэмжээ 34.1% буюу 295.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 31.8% буюу 176.7 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 38.1% буюу 119.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

#### **Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 529 ББСБ-ын 87.7% буюу 464 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 12.3% нь буюу 65 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 23 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 8 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 7 ББСБ байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 13 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**